



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 05 сарын 11 едөр

Дугаар 4/50

Улаанбаатар хот

### Г Унэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дүгээр зүйлийн 47.1, Нийслэлийн Засаг даргын 2016 оны “Найрсаг Улаанбаатар хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай” А/51 дүгээр захирамжийн 27 дахь заалт, тус газрын дүрмийн 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Хот орчмын аяллын чиглэлийг олон улсын стандартын дагуу тохижуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Унэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дарга	Д.Ганболд	Нийслэлийн Аялал жуулчлалын газрын Үйлчилгээний чанар, стандарт хариуцсан ахлах мэргэжилтэн
Гишүүд	О.Амарбаяр	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Стратегийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Авто зам, тээвэр, ложистикийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн
	С.Насанжаргал	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын Барилга байгууламжийн худалдаан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн “Би Ти Энд Ти Си” ХХК-ны захирал
	Г.Баясгалан	
Нарийн бичгийн дарга	Б.Ербахыт	Нийслэлийн Аялал жуулчлалын газрын Хот орчмын аялал жуулчлал хариуцсан мэргэжилтэн

2. Гүйцэтгэгчийг 2016 оны 06 дугаар сарын 26-ны дотор сонгон шалгаруулж, дүнг танилцуулахыг Унэлгээний хороо /Д.Ганболд/-нд даалгасугай.

ДАРГА

Э.БАТТУЛГА

